

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ
ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”
НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-023066
Регистрийн дугаар: 5328209*

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОБНУГазрын мэргэжилтэн:

Увс аймгийн БОГазрын мэргэжилтэн:

Төлөвлөгөө боловсруулсан:

“Хос эрин” ХХК-ний захирал:.....М.Цогбат

Байгаль орчны мэргэжилтэн:.....Э.Мөнгөнтуяа

АГУУЛГА

ОРШИЛ	3
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Төслийн товч тодорхойлолт	4
1.2 2026 онд явагдах уулын ажил, ажиллах горим	4
1.3 Ил уурхайн хүчин чадал, техник-технологи	5
1.3.1 Ил уурхайн хүчин чадал	5
1.3.2 Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж	5
1.4 2026 оны уулын ажлын төлөвлөгөө	5
1.5 Баяжуулалтын технологи	6
1.5.1 Баяжуулах хэсгийн ажиллах горим, хүчин чадал	6
1.6 Дэд бүтэц	6
1.6.1 Усан хангамж	6
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
2.1 Физик газарзүйн нөхцөл	6
2.2 Уур амьсгал	6
2.3 Физик бохирдол, хог хаягдал	7
2.4 Геологийн тогтоц ба геоморфологи	7
2.5 Гадаргын болон газрын доорхи ус	7
2.6 Хөрсөн бүрхэвч	8
2.7 Ургамлан нөмрөг	9
2.8 Амьтны аймаг	9
2.9 Тусгай хамгаалалттай газар нутаг	9
2.10 Түүх соёлын өв	9
2.11 Нийгэм эдийн засгийн байдал	10
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	10
3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
3.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
3.3 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
3.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл	10
БҮЛЭГ 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	10

БҮЛЭГ 5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
БҮЛЭГ 6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
БҮЛЭГ 9. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
БҮЛЭГ 10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	20
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	24
БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ДҮН..	24

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Ашиглалтын технологи	4
Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим ба хугацаа	5
Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	6
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	12
Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	15
Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө	16
Хүснэгт 7 Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө	21
Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	23
Хүснэгт 11 Менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлагнах хуваарь	24
Хүснэгт 12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	25

ОРШИЛ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2026 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон БОННУ-ны хүрээнд хийж гүйцэтгэв.

“Дэмч булаг” нэртэй 537.47га бүхий MV-023066 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастарын хэлтсийн даргын 2025 оны 08-р сарын 18-ны өдрийн 461 тоот шийдвэрээр “Хос эрин”ХХК -д шилжүүлсэн байна.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч тодорхойлолт


Төсөл хэрэгжүүлэгч: “Хос Эрин”ХХК

Регистрийн дугаар: 5328209

Төслийн нэр: “Дэмч булаг”-ын алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл

Төслийн байршил: Увс аймаг Өмнөговь сум

Газар зүйн байршил: “Дэмч булаг” нэртэй MV-023066 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй судалгааны талбай нь засаг захиргааны хуваариар Монгол улсын баруун хойд хэсэг, Увс аймгийн Өмнөговь сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос 1350км, Улаангом хотоос 130, Өмнөговь сумаас 25км зайд байрлана.



Зураг 1. Талбайн байршлын тойм зураг

1.2 2026 онд явагдах уулын ажил, ажиллах горим

Ордыг ашиглах технологи: Ордыг ил аргаар ашиглах бөгөөд уулын ажил явуулах ашиглалтын системийг ордын уул-геологийн нөхцөл, геологийн тогтоц, ордын ашиглалтын хэтийн төлөв байдал зэргийг үндэслэн тээвэртэй гадаад, дотоод хосолмол овоолготой ашиглалтын системээр явуулахаар төлөвлөв. Дэмч булаг алтны шороон ордын агуулагч чулуулаг “Уулын чулуулгийн нэгдсэн ангилалд”-аар III категорид хамаарч байгаа учир “Гипроруда”-ийн баримтлалын дагуу ил уурхайн хажуугийн тогтворжилтыг хангах үүднээс хаалтын доголын өндөр 0.8-5.2м, ажлын доголын хажуугийн өнцөг 60° байхаар төлөвлөв.

Хүснэгт 1 Ашиглалтын технологи

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процесс
	Хөрс хуулалт	Ухаж ачих

Авто тээвэртэй ашиглалтын систем	Элс олборлолт	Тээвэрлэх /Гадаад, дотоод овоолго/
		Ухаж ачих
		Тээвэрлэх /Угаах үйлдвэр/

Ажиллах горим: Уурхай нь 2026 онд 05-р сарын 01-ээс бэлтгэл ажлыг эхлүүлж, 11-р сарыг дуустал хөрс хуулах, элс олборлох, элс угаах, нөхөн сэргээлт хийх болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 12 цагийн уртасгасан хугацаагаар явагдана. Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг, усан сан байгуулах болон угаан баяжуулах тоног төхөөрөмж угсарч монтажлах ажлуудыг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим ба хугацаа

№	Үзүүлэлтүүд	Хугацаа	Эхний жил
1	Хуанлийн өдөр	хоног	365 хоног
3	Жилд ажиллах ажлын хоног	хоног	180 хоног
4	Төлөвлөгөөт бус сул зогсолт	хоног	14 хоног
5	Хоногийн ээлжийн тоо	-	2
6	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	цаг	0.85 цаг

1.3 Ил уурхайн хүчин чадал, техник-технолог

1.3.1 Ил уурхайн хүчин чадал

2026 оны 5-р сард уурхайн бэлтгэл ажлыг хангаж, уурхайд бэлэн байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг үргэлжлүүлэн ашиглах бөгөөд уулын ажлаар 345.07 мян.м3 алттай элсийг олборлон баяжуулах хүчин чадалтайгаар ажиллана.

1.3.2 Ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмж

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайг өөрт байгаа техник, тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан үргэлжлүүлэн ашиглах бөгөөд тэдгээр тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан 2026 оны бүтээлийн тооцоог гүйцэтгэв. Ил уурхайн үндсэн технологийн процесс нь өнгөн хөрсийг бульдозероор хуулж овоолгод байршуулах, хөрсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж гадаад, дотоод овоолгод байршуулах, алттай элсийг экскаватор, автосамосвалын хослолоор тээвэрлэж баяжуулах үйлдвэрийн хажууд овоолгод байршуулах зэрэг ажил гүйцэтгэнэ.

1.4 2026 оны уулын ажлын төлөвлөгөө

Уурхайн бэлтгэл ажил 2026 оны 05-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэнэ.

Тухайн жилд ашиглах блокуудын шимт хөрсийг ялган бульдозероор түрж блокын хилийн гадна шимт хөрсний овоолгод байршуулж үндсэн хөрсийг экскаватор, автосамосвал ашиглан гадаад болон дотоод овоолгод шилжүүлэн байршуулахаар төлөвлөв.

2026 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 785.86 мян.м3 уулын цул хөдөлгөж, 119.91 мян.м3 хөрс хуулж, алт бүхий 345.07 мян.м3 элс олборлоно

Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2026
1	Үржил шимт хөрс хуулалт	мян.м ³	55.11
2	Хөрс хуулалт	мян.м ³	785.86
3	Элс олборлолт	мян.м ³	345.07
4	Хөрс хуулалтын коэффициент	м3/м3	2.43
5	Дундаж агуулга	мг/м3	356.62
6	Металлын хэмжээ /шлихээр/	кг	102.54
7	Металлын хэмжээ /химийн цэврээр/	кг	87.03
8	Металл авалт	%	92.83
9	Металлын хэмжээ /химийн цэврээр/	кг	87.03

1.5 Баяжуулалтын технологи

1.5.1 Баяжуулах хэсгийн ажиллах горим, хүчин чадал

Ордын баяжуулах хэсгийн ажиллах горим нь манай орны улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, ил уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, уурхайн жилийн хүчин чадал зэрэгтэй уялдаж ажиллана. Баяжуулах хэсэг 2025 онд 345.07мян.м3 элс баяжуулан, 97.34 % -ийн металл авалттайгаар баяжуулан 848 сорьцтой 99.81кг шлихийн алт 87.03кг алт /химийн цэврээр/ гарган борлуулахаар байна.

1.6. Дэд бүтэц

1.6.1 Усан хангамж

Технологид шаардлагатай усны хэмжээ:

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжид хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана. Алт олборлож байгаа уурхайнуудын туршлага, үүсмэл нуурын шүүрэлт, усны ууршилт, алдагдал, ордын талбайтай зэргэлдээ олборлолт явуулж байгаа ордын нууруудын шүүрэлт зэргийг үндэслэн шаардагдах усны 25%-ийг цэвэр усаар сэлбэх ба 75%-ийг технологийн эргэлтийн усаар хангах боломжтой байна. Зам талбайн усалгаанд 113тн технологийн ус зарцуулна.

Унд ахуйн усны хэрэглээ

Уурхай нь улирлын чанартай ажиллах ба уурхайн хотхонд байнга 36 хүн ажиллаж амьдарна. Оршин суугч нэг хүний хоногийн усны хэрэглээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар нэг ажилчны ээлжинд буюу ажлын байранд хэрэглэх халуун болон хүйтэн усны хэрэглээ 30л/хон байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Физик газарзүйн нөхцөл

Тус талбай нь Монгол Улсын физик газарзүйн мужлалаар Монгол орны физик газарзүйн мужлалаар Монгол Алтай уулархаг мужийн Түргэний уулархаг мужид багтдаг (Монгол улсын үндэсний атлас, 1985, 2009он).

Дүүргийн болон хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн далайн түвшнээс дээш 1800-2100м үнэмлэхүй өндөр бүхий Хархираагийн нурууны өмнөд хэсэгт уулархаг, эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд Орлогын голын хөндийн дунд оршино.

2.2 Уур амьсгал

Увс аймгийн уур амьсгалын мужлалтын хувьд чийглэг, нэн сэрүүн нэн хүйтэн; хуурайдуу, сэрүүвтэр нэн хүйтэн; хуурай, дулаавтар нэн хүйтэн; нэн хуурай, дулаан хахир хүйтэн бүсүүдэд оршдог. Увс аймгийн дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур $-3.4...+0.7^{\circ}\text{C}$ бөгөөд өвлийн улиралд $-27.4. 13.9^{\circ}\text{C}$, хаврын улиралд -

$2.4...+3.5^{\circ}\text{C}$, зуны улиралд $+14.7...+20.3^{\circ}\text{C}$, намрын улиралд $-1.9...2.0^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэнэ. Хур тунадасны хувьд жилийн нийлбэр хур тунадас $62.6...254.0\text{мм}$ бөгөөд өвлийн улиралд $3.1...13.8\text{мм}$, хаврын улиралд $4.9...42.5\text{мм}$, зуны улиралд $48.6. 148.2\text{мм}$,

намрын улиралд $6.0. 57.7\text{мм}$ –ийн хооронд хэлбэлзэнэ.

2005-2019 оны олон жилийн явцаас харахад жилийн агаарын дундаж температур ойролцоогоор 0.6°C -аар дулаарсан байна. Энэ хугацаанд хамгийн хүйтэн жилийн агаарын дундаж температур 2005 онд -3.4°C , хамгийн дулаан жилийн агаарын дундаж температур 2007 онд -0.5°C байжээ.

Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтийн мөн адил өссөн хандлагатай бөгөөд жилийн нийлбэр хур тунадасны хэмжээ $75. 225\text{мм}$ -ийн хооронд хэлбэлзсэн байна.

Судалгааны талбай нь эх газрын гүнд, далайн түвшнээс дээш ихээхэн өндөрт оршдог юуны өмнө агаарын температурт нөлөөлж өвлийн улирлыг урт, тогтмол хүйтэн болон хавар, намрын улирал богинохон болдог. Хамгийн хүйтэн үе нь 1-р сард - 400C , хамгийн халуун үе нь 7-р сард $+ 300\text{C}$ байдаг. Жилд дунджаар 200мм тунадас унах ба ихэнх нь 7,8- р саруудад унадаг. Анхны цас 9-р сард орж нийт нутгаар 4-р сарын дунд үе хүртэл цасан бүрхүүл тогтоох ба Түргэн уул оройнууд нь мөнх цасан бүрхүүлтэй. 10-р сарын дунд үеэс газрын хөрс хөлдөж эхлэх ба хөлдөлтийн гүн нь 2м хүрнэ. Өндөр уулсын орой, голын хөндийн эхээр (2000м -ээс дээш өндөрт орших) мөнх цэвдгийн бүстэй.

2.3 Агаарын чанар

Төслийн талбайд $\text{PM}_{10.0}$ ширхэглэгтэй тоосны нягтшил 0.012мг/м^3 байгаа нь Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016) стандартын хүлцэх агууламжаас нэн бага байна.

Дээрх үр дүнгээс үзэхэд гадаад орчны агаар дахь тоосонцрын хэмжээ “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 ” стандартад заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй байна. Төслийн талбай дотор авсан дуу шуугианы хэмжээ мөн адил дБА байгаа нь MNS 4585:2016 Агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна.

2.4 Геологийн тогтоц ба геоморфологи

Хайгуулын талбай нь Монгол Алтайн каледоны атираат тогтолцооны зүүн хэсэг Урал Монголын атираат бүсийн өмнөд төгсгөлд оршдог бөгөөд геологийн тогтцын хувьд түрүү дунд юрагийн настай тунамал хурдас, кайнозойн настай тунамал сэвсгэр хурдсууд тархсан байдаг. Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай

нь хойноосоо урагшаа сунасан Орлогын голын хөндий болон түргэний өргөгдлийн хэмжээнд байршина. Дэмч булаг алтны орд нь Орлогын голын 1-р дэнж дээр байршина. Талбайгаас дээш хэсэгт голын хөндий харьцангуй нарийхан бөгөөд уулсын дундуур урсдаг бол хайгуулын талбайн орчимд харьцангуй өргөсч 1-р дэнжийн өргөн нь 450м орчим болсон байдаг. Ордын орчимд дараах дараах хурдас чулуулаг тархана. Голын хөндий болон дэнжүүдээр 1м хүртэл хэмжээтэй интрузив чулуулагийн бул чулуу ховроор тархах ба хайрга хайрганцар бүхий элсэрхэг цайвар шаргал, цайвар саарал өнгийн хурдас тархана.

Хайгуулын талбай нь байршлаараа Монгол Алтайн уулсын зүүн хажуу хэсэгт Алтай - Хархираагийн өргөгдлийн бүсэд оршдог. Судлаач И.К Молоткова / Дёмин ба бусад 1990 он/ нарын саналаар орчин үеийн газрын гадарга нь олон янзын настай гүний чулуулгийн изостатик хайлалт ба инъектив царцалт, боржинлог чулуулаг үүсэх үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзээд үүнд: Талбайн орчимд тархсан боржингийн найрлагтай Хархираагийн, Түргэн уулын, Шар ухаагийн, Ачит нуурын гэсэн 4 үндсэн массив байна хэмээжээ. Орчин үеийн гадаргын хэлбэр төрх бүрэлдэн бий болоход дээрх үйл явц болон экзоген процесс болон голчлон нөлөөлжээ.

2.5 Гадаргын болон газрын доорхи ус

Талбайн хувьд Хар нуур-Ховд голын ай савд хамаарагддаг. Усан сүлжээ сайн хөгжсөн бөгөөд судалгааны талбай орших дүүргийн зүүн хойд хэсгээр байнгын урсгал устай дунджаар 5-15м өргөнтэй, 0.3-1.5м гүнтэй, 3-4м/сек урсгалын хурд бүхий Бургастайн гол, Орлогын гол гэх мэт голууд бүгд цэвэр тунгалаг устай хүн малын ундны хэрэгцээнд ашигладаг. Голуудын усны түвшин хур тунадасны хэмжээнээс хамаарах ба зуны саруудад усны хэмжээ элбэг ажиглагддаг ба намрын саруудад доод түвшинд хүрдэг. Голууд нь 10- 11-р. саруудад хөлдөж, 5-р сард гэдэг байна.

Хайгуулын талбайн зүүн захаар Орлогын гол урсах бөгөөд талбайд үүнээс өөр уст цэг худаг булаг байхгүй, талбайгаас хойд зүгт 3км-т Орлогын голд баруун талаас нь Цөнхөгийн гол нийлэн урсаж 30км орчим урсан Намирын гол гэж нэрлэгдэн

Талбайн гидрогеологи: Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн орчмын 1:500,000- ны масштабтай гидрогеологийн зураглал тайлангийн ажлыг Н.Жадамбаа нар (1998 он), хийж гүйцэтгэсэн. Ажлын үр дүнд талбай орчмын гол, нуурын уснаас дээжлэлт хийн химийн шинжилгээ хийж тодорхой түвшинд судалсан байдаг. Баруун монголын район нь гидрогеологийн тогтцоороо уулс хоорондын хотгор, томоохон хөндийнүүд, тектоникийн өргөгдлүүдтэй холбоотой нэлээд нийлмэл артезийн усны сав газруудтай байдаг. Хотгорууд нь ерөнхийдөө мезокайнозойн тунамал хурдсаар дүүргэгдсэн байх бөгөөд тэнд ихэвчлэн нүх сүвний уст бүрдэл үүссэн байдаг бол тектоникийн өргөгдлийн хэсэгт янз бүрийн настай хувирмал, тунамал, эффүзив тунамал ба эффүзив болон гүний чулуулгууд байх ба энд ан цавын бүс дэх хөлдөлтийн бүсийн доорх ан цавын ба судлын уст бүрдэл оршдог. Харин газрын гадаргын түвшнээс доош дөрөвдөгчийн хурдас дахь уст үе нь нүх сүвийн уст бүрдэлд хамаарна. Судалгааны талбай нь 1- р зэргийн томоохон гидрогеологийн структур болох Монгол Алтайн гидрогеологийн массивт хамаардаг. Дээрх массив нь 2-р зэргийн Хархираа-Алтан хөхийн хагарал ан цавын уст структур Хөрсний болон ан цавын ус агуулсан уулс хоорондын хотгор структурт хуваагдах бөгөөд талбайн гидрогеологийн онцлог нь түүний олон жилийн цэвдэгтэй.

2.7 Ургамлан нөмрөг

Увс аймгийн Өмнөговь сумын нутагт орших төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Ховдын уулын хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).

Ховдын уулын цөлжсөн хээрийн тойрогт Монгол Алтайн хойд хэсэг болох Хархираа, Түргэн, Алтан Хөхийн уулс, Сийлхэмийн нуруу болон Ачит нуурын цөлжсөн хотгор хөндийг өөртөө багтаана. Энд Алтайн өндөр уулсын хуурайсаг элементүүдийн зэрэгцээ говийн цөлөрхөг хээрийн төлөөлөгчид их үүрэгтэй бөгөөд нийт 1041 зүйлтэй бөгөөд зөвхөн энд ургадаг 22 зүйл ургамал тэмдэглэгдсэн.

Монгол оронд 27 овгийн 45 төрлийн 86 зүйл усны гуурст ургамал тэмдэглэгдсэнээс Хар нуур-Ховд, голын сав газарт 53 зүйл тэмдэглэгджээ (В.И. Грубов 1982).

2.8 Амьтны аймаг

Судалгааны талбайд 5 багийн 27 зүйл хөхтөн таарах боломжтой. Энэ нутгийн хөхтөн амьтны цөмийг мэрэгчдийн багийн төлөөлөгчид бүрдүүлнэ. Говийн болон хуурай хээрийн төлөөлөгчид түлхүү байршин амьдарна. Эдгээрийг дагаад жижиг махчид болох үен, эрээн болон өмхий хүрнэ, үнэг, хярс элбэг. Задгай талбай ихтэй тул том туруутан болон том махчин амьдрах орчноор хомс. Өмнөговь сумын баруун хил дагуу ховд голд минж, уулаараа аргаль, янгир зэрэг нэн ховор, ховор амьтад байдаг боловч байршил нь төслийн талбайгаас алс тул бид жагсаалтанд оруулаагүй болно. Судалгааны талбай дээр Монгол орны ховор зүйлийн жагсаалт болон улаан номонд орсон эрээн хүрний тархац нутагтай судалгааны талбай давхцана. Энэ нутагт тархсан хөхтөн амьтдаас Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) II хавсралтад саарал чоно, мануул орсон.

2.9 Тусгай хамгаалалттай газар нутаг

Увс аймгийн нутагт нийт 7 УТХГ нутаг байрлана харин Өмнөговь сумын хувьд 1 ширхэг орон нутгийн ТХГН байрлах ба төслийн талбай нь Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

2.10 Түүх соёлын өв

Аймгийн хэмжээнд 10-н түүх, соёлын үл хөдлөх дурсгал байх ба үүнээс Жаргалант сумын хэмжээнд 1 түүх соёлын үл хөдлөх өв бүртгэгдсэн байна.

Дэмчбулаг нэртэй тус талбайд ямарваа нэг үйл ажиллагаа явуулах тохиолдолд “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 27.8 заалтыг үндэслэн археологийн авран хамгаалах малтлага судалгаа хийлгэх шаардлагатай хэмээн үзэж, үйл ажиллагаа явуулахад өртөж болохуйц 29-н булш оршуулгын дурсгалыг малтан судлуулж авран хамгаалах талбай чөлөөлөх археологийн малтлага судалгааны ажлыг ШУА-АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН- гээр 2025 оны 5 дугаар сарын 16 ноос 6-р сарын 14-н хүртэл хийж гүйцэтгүүлсэн байна.

Төслийн талбайд Палеонтологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Р. Барсболд(Sc.D), эрдэм шинжилгээний ажилтан Б. Буянтэгш, С. Хүрэлбаатар нарын бүрэлдэхүүнтэй баг урьдчилан хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Тайланд дурдаж дүгнэлт хийснээр талбайд түрүү-хожуу карбоны Ёлын интрузив бүрдэл, доод-дунд юрийн Жаргалант формацын тунамал, терриген чулуулаг мөн талбайн ихэнх хэсэгт дөрөвдөгч, орчин үеийн сэвсгэр хурдас тархсан

ба эдгээр чулуулгаас эртний шим ертөнцийн олдвор энэ удаагийн хайгуул судалгаагаар илрээгүй тухайг тэмдэглэсэн байна.

2.11 Нийгэм эдийн засгийн байдал

Анх 1924 онд Өлзийжаргалант уулын сум нэртэйгээр үүсэж 1931 оноос Өмнөговь сум хэмээн нэрлэгдэх болсон. Нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байрлал. 314.6 мян.ам.дөр.км газар нутаг эзлэн Увс, Ховд, Баян-Өлгий гурван аймгийн хилийн зааг бэлчирт оршдогоороо давуу талтай, аль ч аймагтайгаа харилцах бүрэн боломжтой. Хөрш зэргэлдээ аймаг, сумд. Баян-Өлгий аймгийн Баяннуур, Ховд аймгийн Мянгад, Эрдэнэбүрэн, өөрийн аймгийн Ховд, Тариалан, Наранбулаг, Өлгий зэрэг 3 аймгийн 7 сумтай хиллэдэг.

Хүн амын 98% нь дөрвөд ястан, үлдсэн хувь нь баяд, халх, сартуул, хотон, мянгад, урианхай зэрэг олон ястнууд амьдардаг.

Өмнөговь сумын хэмжээнд 2021 онд 4772 хүн амьдарч байгаа ба өмнөх онуудтай харьцуулахад өссөн үзүүлэлттэй байна. Сумын хэмжээнд 2021 оны байдлаар 1154 өрх амьдарч байгаа ба 2019 болон 2020 оноос өссөн үзүүлэлттэй байна.

Малын бүтэц 2021 оны жилийн эцсээр адуу 8.6 мян.толгой, үхэр 11.5 мян.толгой, хонь 122.2 мян.толгой, ямаа 120.6 мян.толгой тус тус тоологдсон ба Өмнөговь сумын хэмжээнд 264.7 мян.толгой мал тоологдсон байна.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2026 онд уулын ажлын хөрс хуулалт, олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсч агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2 Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3 Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2026 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.4 Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

БҮЛЭГ 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хос эрин”ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй.

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, засгийн газар, БОУАӨЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

**УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Нийт тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм;	Мот/цаг, засвар үйлчилгээ	300000	Төслийн хугацаанд	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2025 - MNS 3384:82
		Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг тогтмол усалж байна.	Дотоод тээврийн зам, биологийн нөхөн сэргээлтийн талбай	Нэгж усалгаа	500000		
		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ.	Уурхайд ашиглагдаж буй замууд	-	-		
		Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.	Уурхайн хэмжээнд	-	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон		
		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	-		
		Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр - Эрчим хүчийг хэмнэж үр ашигтай зарцуулах	Уурхайн хэмжээнд		500000		
	Нийт	1 300 000					

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө	Дотоод үйл ажиллагааны зардалд			Төслийн хугацаанд	Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
		Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх - Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	1 500 000				
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Хяналт шинжилгээний ажлын зардалд орсон				
Нийт		1 500 000					
3.	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Дотоод үйл ажиллагааны зардалд			Төслийн хугацаанд	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Уурхайн хуулсан Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих ургамалжуулах зардал , нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглаж буй тооцоог хянах, бүртгэл хөтлөх	Шимт хөрсний овоолго	Хөтөлсөн бүртгэл	200 000	2026 онд	
		Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах	Засвар үйлчилгээний талбай	Хамгаалсан талбай	-	Төслийн хугацаанд	
		Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын талбай, авто зогсоол, карьер	Саармагжуулах материал	1 500 000	Төслийн хугацаанд	
Нийт		1 700 000					
4	Ургамлан нөмрөг	Олон салаа зам гаргахгүй байна.		-		Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	болон Амьтны аймаг	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	Олгосон зөвшөөрөл, бүртгэл	Дотоод үйл ажиллагааны зардалд		- Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхон, засварын талбайд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	300 000	Төслийн хугацаанд	
		Ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой сургалт хийх	Уурхайн хэмжээнд	-	-	2 жилд 1 удаа	
Нийт			300 000				
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал 4 800 000							

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ
ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны эцсийн байдлаар нийт 35.68 га газар эвдрэлд өртөх ба 2026 онд 35.68 га талбайд дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөв. Олборлолтын эхний жил учир биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй болно.

Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	га	35.68	-	112320000	
	Нийт	112320000				

БҮЛЭГ 6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хос эрин”ХХК нь дүйцүүлэн хамгаалах ажлыг БОННУ-д тусгаснаар төслийн талбайн хойд зүгт хууль бусаар уурхайлалтанд өртөж эвдэрсэн талай байдаг. Малчид ард иргэдтэй хийсэн уулзалтаар мал амьтан удаа дараа унаж энддэг тухай саналыг өгч нөхөн сэргээж өгөх хүсэлтийг өгч БОННУ—ны дүйцүүлэн хамгаалах ажилд тусгаж оруулсан байна. Тиймээс эвдрэлд орсон талбайн нүхнүүдийг булж тэгшлэх аюугүй болгох ажлыг хийж гүйцэтгэх ажлын тусгаж оруулав.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутгаас заасан газарт 2500ш мод тарихаар төлөвлөөд байна.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	БОННУ-д тусгаснаар хууль бусаар уурхайлалтанд өртөж эвдэрсэн талайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.	Га	5	2500000	25000000	7 сард	БОННУ

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ
ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2	2026 онд 2500 ш мод заасан чиглэлд тарихаар төлөвлөв	ш	2500	10000	25000000	9-10 сард	Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд
Нийт		50000000					

Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө

БҮЛЭГ 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

БҮЛЭГ 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хос эрин”ХХК-ний Дэмч булаг алтны шороон ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Өмнөговь сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

БҮЛЭГ 9. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

Хүснэгт 7 Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хээрийн түймрээс сэргийлж уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулах	ш	1	-	Үйл ажиллагааны зардал орно	5-10 сард	
2	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулах	ш	1		Үйл ажиллагааны зардал орно		
	Мэргэжлийн байгууллагаар ХАБ сургалт зохион байгуулах	ш	1		Үйл ажиллагааны зардал орно		
Нийт							

БҮЛЭГ 10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно. 2026 онд хийгдэх хамгийн том ажил нь 75 хүний хүчин чадал бүхий ахуйн бохир цэвэрлэх байгууламж худалдан авч суурьлуулж байна.

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын цэг засвар хийх, хатуу хог хаягдлыг доторжуулах, зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хог хаягдлын цэгт хаях.	-	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21 -р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл
		Ахуйн бохир цэвэрлэх байгууламж худалдаж авах	47000000	Үйл ажиллагааны турш	
		Ахуйн бохир орчмын хөрсөнд бактерлогийн шинжилгээ хийлгэх	Орчны хяналт шинжилгээний ажилд орсон	5-р сард	
		Хог хаягдал, ялган ангилалт, түүний үр ашгийн талаар сургалт, мэдлэг олгох	-	Үйл ажиллагааны турш	
		Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялган тушаах	-	Үйл ажиллагааны турш	
		Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын хэмжээг тогтоож орон нутагт улирал тутамд мэдээлж байна.	-	Үйл ажиллагааны турш	
2.	Үйлдвэрийн	Уурхайн техникүүдийн засварын цех, мөн уурхайн техникт ашигласан, сольсон тос маслыг сар бүр тусгайлсан савт хуримтлуулна. Хаягдал техникийн тос, масло хуримтлуулах /сар болгон аюултай хаягдлаа 1 удаа гэрээ хийсэн газарт нийлүүлэх зайлуулах/	-	Үйл ажиллагааны турш	
		Уул уурхайн тоног төхөөрөмжөөс гарах нефтийн бүтээгдэхүүний үлдэгдэл	-	Үйл ажиллагааны турш	

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		хаягдлыг хаягдал зайлуулах газарт шилжүүлэн хаяна.			
Нийт зардал 47000000					

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ
ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах төлөвлөгөө авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- ✓ Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө боловсруулах
- ✓ Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2026 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаар төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүү д	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтам жийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Агаар	Нөхөн сэргээлт хийсэн талбай, Засварын талбай ажилчдын хотхон, уурхайн карьерь, уурхайн зам	6, 10-р саруудад нэг удаа	2 цэгт 2 удаа	50 000	500000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, , дуу чимээ,агаарын харьцангуй чийгшил	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2.	Хөрс	шимт хөрсний овоолго, , засварын газар, ШТС орчим	6, 10-р саруудад нэг удаа	3 цэгт 2 удаа	Хөрсний хяналт шинжилгээний 1- 2 цэгт жилд 2 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 35000 төг Газарзүйн хүрээнгийн Хөрсний лаборатрид Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 45.0 мян.төг “Ханлаб” лаборатори	330000	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.	Ус	Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур, Орлого голоос	6, 10-р саруудад нэг удаа	5 цэгт 2 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ нэгжийн үнэ 50000 төг, Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 141700 төг *УСУГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ Мөн элс угаан баяжуулах нуурын усанд хүнд металлын шинжилгээ өгнө.	1000000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, pH, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO₄, NO₂, NO₃, CO₃, HCO₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, pH, цахилгаан дамжуулах чанар)	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/A/171 тоот тушаалын 2-р хавсралт.
Нийт		1880000						

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ
ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар
осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь 2026 он	Хариуцсан албан тушаалтан
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Төслийн хугацаанд	Уурхайн дарга
2.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх	11-р сар	“Хос эрин”ХХК-ийн удирдлагууд
3.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих	Сар бүр	“Хос эрин”ХХК-ийн удирдлагууд

**БҮЛЭГ 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГИЙН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ**

Хүснэгт 11 Менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
1.	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэд, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.	9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.
2.		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	11 сарын 1-нд багтаан		
3.		Нөхөн сэргээлтийг танилцуулж улсын комисст хүлээлгэн өгөх.	10-р сараас 12-р сарын 1-нд багтаан		

БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ДҮН

Хүснэгт 12 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Д-д	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	1300000
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний ажлын зардал	1700000
3	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	300000
4	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	1500000
5	Хог хаягдлын менежментээр хийгдсэн ажлын зардал	47000000
	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний төлөвлөгөө	-
7	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	112320000
8	Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн зардал	50000000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1880000
	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	216000000

БОННУ-д тусгасан 2026 оны байгаль хамгаалах нийт зардал болох 216 сая төгрөг тусгасан бөгөөд уулын ажил оройтож эхлэхтэй холбоотой БОМТ -ын зардал 216 сая төг боллоо.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 216 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд 50% болох 108 сая төгрөгийг нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр болгон байршуулав.

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭМЧ БУЛАГ”-ЫН АЛТНЫ
ШОРОН ОРДЫН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 423336448

Татсан огноо: 2026-06-22 14:06

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
2725108269 MN120015002725108269	MN780090100900013406 MN780090100900013406	31,500,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ХОС-ЭРИН	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний утга Хос Эрин ХХК-ийн 2026 оны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр Гүйлгээний огноо 2026-06-22	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
Б. Энх-Амгалан		



Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 425512201

Татсан огноо: 2026-07-02 11:36

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
2725108269 MN120015002725108269	MN780090100900013406 MN780090100900013406	76,500,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ХОС-ЭРИН	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний утга Хос эрин ХХК 2026оны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө Гүйлгээний огноо 2026-07-02	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
Б. Энх-Амгалан		

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

2026 оны барьцаа төлбөр төлсөн баримт